ДОРНОД АЙМАГ
БАЯНТҮМЭН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 01 сарын 12 өдөр Дугаар 10/01 Цагаан дэрс

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүс тогтоох тухай" 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. "Мөнх дулаан хайрхан" ХХК-ийн хүссэн 27,94 гектар талбай нь сумын Жаргалант багийн Зүүн Өлзийтийн зүүн дор гэх газар байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн хариуцан хамгаалах газар нутагтай кадастрын зураглал давхцалтай, Зүрхийн тал байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор "татгалзах санал"-ыг ирүүлсэн, Хэрлэн голын энгийн болон онцгой хамгаалалтын бүс дотор орж байгаа тул түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох эсэх саналыг хэлэлцэж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 100 хувийн саналаар дэмжих боломжгүй гэж саналыг хүргүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА Ж.БАТЧУЛУУН

2126010002